



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 27 -ны өдөр

Дугаар А/04

Эрдэнэт

Албан хаагчдыг халдвараас сэргийлэх,  
аминдэмжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын 22-ны өдрийн “Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай” 19 дүгээр албан даалгавар, Засаг даргын 2020 оны 01 сарын 27-ны өдрийн А/35 захирамж, Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 10 сарын 01-ний өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” Б/32 дугаар тушаалын 7.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байранд 2020 оны 01 сарын 27-ны өдрөөс 2020 оны 03 сарын 06-ны өдрийг дуустал амин дэмээр хангах, эрүүл мэндийг дэмжих, халдвар хамгаалалтын хэрэгсэл олгож урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсугай.

2. Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, аминдэмжүүлэлтийн нэр төрөл болон халдвар хамгаалалтын хэрэгсэл олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Холбогдох санхүүгийн зардлыг гаргахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн /С. Мөнхзул/-д даалгасугай.

ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

ЭМГ-ын даргын 2020 оны 21 сарын 27-ны өдрийн  
А/ОЧ.тушаалын хавсралт

**ЭМГ-ын ажилчдыг аминдэмжүүлэлт болон халдвар хамгаалалд шаардлагатай  
төсвийн тооцоо /ажлын 30 хоногоор/**

№	Хэрэглэгдэхүүний нэр төрөл	Тоо/ширхэг/	Нэг бүрийн үнэ/төг/	Нийт төсөв
1	Витагрипп	685	698	478.130
2	Витагрипп	170	589	100.130
3	Чацаргана	56	5850	327.600
4	Гар халдваргүйжүүлэгч /гель 1л/	4x1л	8420	33.680
5	Гар халдваргүйжүүлэгч /гель/	9	1350	12.150
6	Амны хаалт	1100	100	110.000
7	Амны хаалт N95 /шүүлтүүр /	15	3600	54.000
<b>Нийт 1.115.690 төгрөг</b>				